

**НИЙТИЙН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН "АЛБАН ХААГЧДЫН АЖИЛЛАХ НӨХЦӨЛ,  
НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨР"-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ 2019 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТ**

№	Хөтөлбөрийн үндсэн чиглэл	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Биелэлт	Хувь
<b>5.1. Ажлын байр, ажиллах нөхцлийг сайжруулах чиглэлээр:</b>				
1	<p>5.1.1. Хэлтэс нэгжүүдийн чиг үүргийг нарийвчлан тогтоож, албан хаагчдын ажлын ачааллыг тэнцвэржүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллах</p>	<p>Төрийн албаны зөвлөлийн 2019 оны "Төрийн жинхэнэ албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалд тавигдах тусгай шаардлагыг батлах тухай" 02 дугаар тогтоол, "Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам батлах тухай" –ын 03 дугаар тогтоолын дагуу Төрийн албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг албан тушаал тус бүрээр шинэчлэн боловсруулах.</p>	<p>Тус газрын үндсэн зорилго, зорилт, чиг үүргийг нарийвчлан тодорхойлох, ажлын байрны шинжилгээ хийх, албан тушаалын тодорхойлолтуудыг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг тус газрын даргын 2019.06.24-ний өдрийн А/37 дугаар тушаалаар баталгаажуулсан. Ажлын хэсэг 2019.06.25, 06.28-ны өдөр хуралдсан. 2019.06.25-ны өдрийн хурлаар: Хэлтэс тус бүр газрын шинэчилсэн дүрмийн заалтуудаас өөр өөрийн хэлтэст хамааралтай заалтуудыг ялган тэмдэглээг хийсэн. 2019.06.28-ны хурлаар: Тус газрын даргын 2017 оны А/16-р тушаалаар баталсан "Зохион байгуулалтын нэгжүүдийн үйл ажиллагааны чиг үүргийг батлах тухай" тушаалыг өөрчлөн баталгаажуулах, хэлтэс тус бүр өөр өөрсдийн хамааралтай заалтуудыг салгаж шинэчлэх, өөрчлөлт оруулах талаар ярилцаж, тус тусын чиг үүргийг гаргахаар тохирсон. Хэлтсүүдээс чиг үүргийг нь авч нэгтгэх ажил хийгдэж байна.</p>	60
2	<p>5.1.2. Ажлын байранд тавигдах стандартын шаардлагын дагуу нэг албан хаагчид ногдох талбайн хэмжээг нэмэгдүүлэх, агааржуулалтын асуудлыг шийдвэрлэх</p>	<p>Нийслэлийн төр захиргааны байгууллагуудыг нийслэлийн Хан-Уул дүүргийн 4, 8 дугаар хорооны нутаг дэвсгэр /Яармаг шинэ төв/-т шилжүүлэн байршуулах ажил төлөвлөгдөж байгаатай холбогдуулан НЗДТГ, Ерөнхий төлөвлөгөөний газарт ажлын байрны талаарх саналаа хүргүүлэх</p>	<p>НЗДТГ, Ерөнхий төлөвлөгөөний газарт ажлын байрны талаарх саналаа 2019.01.28-ны өдрийн 1/139 тоот албан бичгээр хүргүүлсэн.</p>	100
3	<p>5.1.3. Ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай техник, тоног төхөөрөмж, бичиг хэрэгслийн хангалтыг сайжруулах</p>	<p>Ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай техник хэрэгсэл, бичиг хэрэгслийг батлагдсан төсвийн хүрээнд нэмэгдүүлэх, сайжруулах</p>	<p>Бичиг хэргийн материалд 2018 оны эхний хагас жилийн байдлаар 4.3 сая төгрөг зарцуулсан бол 2019 оны эхний хагас жилийн ХБГ-ийн тайлангаар бичиг хэргийн материалд 6,8 сая.төгрөг зарцуулсан байна.</p>	100

5.2. Албан хаагчдын ахуй нөхцөл, нийгмийн баталгааг хангах чиглэлээр

4	<p>5.2.1. Албан хаагчдын төлөвлөгөө, ажилласан жил, үр чадварыг нь харгалзан зэрэг дэв, ажилласан жилийг нэмэгдүүлэх асуудлыг тухай бүр нь шийдвэрлэх</p>	<p>а/ Төрийн захиргааны албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, үнэлгээний дагуу хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг үндэслэн ажилласан жилийн болон цалингийн шатлалыг нэмэгдүүлэн, тушаалаар баталгаажуулах б/ Төрийн захиргааны албан хаагчдад зэрэг дэв олгох, нэмэгдүүлэх саналаа Нийслэлийн Засаг даргын тамгын газарт хүргүүлэх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлж, тушаалаар баталгаажуулах</p>	<p>Төрийн захиргааны 6 албан хаагчийн ажилласан жилийг хууль тогтоомжийн дагуу нэмэгдүүлэн, газрын даргын 2019.02.19-ны өдрийн Б/25 дугаар тушаалаар баталгаажуулсан. 3. Хэлтсүүдээс үр дүнгийн гэрээ дүгнэж ирүүлсэн "Илтгэх хуудас"-ыг үндэслэн 10 албан хаагчийн цалингийн шатлалыг нэмэгдүүлж, газрын даргын 2019.02.19-ны өдрийн Б/24 дүгээр тушаалаар баталгаажуулсан. 4. Төрийн захиргааны албан хаагчдад зэрэг дэв олгох, нэмэгдүүлэх саналаа 2019.03.22-ны өдрийн 1/420 тоотгоор Нийслэлийн Засаг даргын тамгын газарт хүргүүлсэн. Нийслэлийн засаг даргын 2019 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн А/491 дүгээр захирамжаар нэр бүхий албан хаагчдад зэрэг зэв олгох шийдвэр гарснаар түүнийг үндэслэн газрын даргын 2019.05.28-ны Б/59 дүгээр тушаалаар баталгаажуулан зэрэг дэвийг олгож байна.</p>	100
5	<p>5.2.2. Албан хаагчдын холбогдох журмын дагуу дүгнэж, мөнгөн урамшуулал олгох</p>	<p>а/ Хэлтэс тус бүрээс албан хаагчдынхаа гүйцэтгэлийн төлөвлөгөөг холбогдох журмын дагуу үнэлж дүгнэх. б/ Гүйцэтгэлийн төлөвлөгөөг үнэлж дүгнэсэн материалуудыг нь нэгтгэх, саналыг нь үндэслэн урамшуулал олгох тушаал шийдвэр гаргах</p>	Хугацаа болоогүй	0
7	<p>5.2.7. Тус газар тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллаж буй албан хаагчдад аминдаа орон сууц, зуслангийн газартай болох, өөрийн хүсэлтээр суралцах болон хүүхдээ сургахад нь хууль тогтоомжийн дагуу дэмжлэг үзүүлэх</p>	<p>Албан хаагчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх, хүний нөөцийн чадавхийг сайжруулах зорилгоор суралтанд хамрагдах, суралцахад нь дэмжлэг тусалцаа үзүүлэх</p>	<p>Тус газрын "Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, сургалт, нийгмийн баталгааг хангах талаар 2015-2019 онд хэрэгжүүлэх хөтөлбөр"-ийн дагуу байгууллагын 2019 оны "Сургалтын төлөвлөгөө"-г боловсруулж баталгаажууллаа. Сургалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хагас жилийн байдлаар 15 төрлийн сургалтад давхардсан тоогоор 194 албан хаагч хамрагдаад байна.</p>	100

8	Албан хаагчдад сар бүр олгох хоол, унааны зардлыг нэмэгдүүлэх	Батлагдсан төсвийн хүрээнд албан хаагчдын хоол унааны зардлыг нэмэгдүүлэх	Тус газрын албан хаагчдын хоолны зардалд нэг хүний 2600 төгрөг байсныг 4500 төгрөг болгож, газрын даргын 2019.01.14-ний өдрийн Б/07 дугаар тушаалаар өөрчилсөн.	100
<b>5.3. Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр:</b>				
9	5.3.1. Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, байнгын хяналтанд байлгах, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор нарийн мэргэжлийн эмч ажиллуулах	Албан хаагчдын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд "Элэг бүтэн Монгол хөтөлбөр"-ийн дагуу элэгний В, С вирус илрүүлэх шинжилгээнд хамруулж шинжилгээний хариуг үндэслэн 3 тунт вакцины сүүлийн тунг хийлгэх	<p>а) Бүх албан хаагчдын дунд элэгний В, С вирусын шинжилгээ, вакцинд хамрагдсан эсэх судалгаа хийв. б) 2019.02.22-ны өдөр байгууллагын нийт албан хаагчдад эмчийн булангаар зар түгээж "Хаппи Веритас" оношилгооны төвийн захирал Г.Батгэрэл эмчийг урьж элэгний В, С вирус, ходоодны хеликобактерийн талаар сургалт зохион байгууллаа. с) "Сайн чагнуур" өрхийн эрүүл мэндийн төвтэй хамтран элэгний В, С вирус илрүүлэх шинжилгээнд хамруулав.</p> <p>д) Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төвийн Дархлаажуулалтын алба, Халдварт өвчин судлалын үндэсний төвтэй хамтран тус шинжилгээний хариуг үндэслэн вакцин хийлгэх шаардлагатай 43 албан хаагчдыг элэгний В вирусын 3 тунт вакциныг товлолын дагуу 2019.05.20-ны өдөр тус тус хийж дуусгав.</p>	100
	5.3.1. Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, байнгын хяналтанд байлгах, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор нарийн мэргэжлийн эмч ажиллуулах	Халдварт бус өвчний эрт илрүүлэг, хяналтын ажлын хүрээнд чихрийн шижин өвчний шинжилгээ хийх  Төрөх насны эмэгтэйчүүдийн судалгаа гаргаж, хянаж, заавар зөвөлгөө өгөх	<p>Чихрийн шижин өвчний шинжилгээг бүх албан хаагчдын дунд хийхэд 4 албан хаагчдад чихрийн шижин өвчний эрт үеийн шинж илэрсэн ба цаашид авах арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэх мөн сар бүр давтан шинжилгээ хийж, хянаж, зөв хооллолтын талаар эрүүл мэндийн заавар зөвөлгөө өгч ажиллаж байна.</p> <p>Судалгаа гаргаж заавар зөвөлгөө өгч ажиллаж байна.</p>	95
		2017 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр батлагдсан "Эрүүл ажлын байр удирдамж"-ын хүрээнд зөв хооллолт, эрүүл амьдралын хэв маяг талаарх сургалт зохион байгуулах	2017 оны 07 дугаар сарын 01-ний өдөр зөв хооллолт, эрүүл амьдралын хэв маяг талаарх сургалт зохион байгуулсан.	100

11	<p>5.3.3. Нийслэлийн өмчит эмнэлэг, сувилалд эмчилгээ, сувилгаа хийлгүүлэх хүсэлтэй албан хаагчдыг дэмжин тусалж, нийт албан хаагчдыг нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгт хамруулах, эмчийн хяналтын картыг байнга хөтлүүлэх зэрэг арга хэмжээнүүдийг шат дараалан авах</p>	<p>Албан хаагчдын эмчийн хяналтын карт нээж картжуулах, хяналтын картыг байнга хөтлөх, "Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл мэндийн төв"-тэй хамтран шаардлагатай албан хаагчийг нарийн мэргэжлийн эмч рүү илгээх</p>	<p>Эрсдэлт бүлгийн өвчтэй хүмүүст карт нээж, онцгой анхаарал тавьж өвчлөлийг бууруулах эмчилгээ хийж, өдөр тутам зөвлөгөө өгч ажилласан болно. Өдөр тутам ажилчдад шаардлагатай тохиолдолд үзлэг хийж, үзлэг хийсэн тухай журнал хөтлөн ажиллаж байна. 2019 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар давхардсан тоогоор нийт 432 албан хаагчдад үзлэг, эмчилгээ хийж, үйлчлүүлэгч тус бүрт зөвлөгөө өгч, шаардлагатай нь эмчилгээг тухай бүр хийж ажилласан. Үзлэг эмчилгээнд хамрагдаж байгаа албан хаагчдын дийлэнх хувь нь хөдөлгөөний дутагдал, таргалалттай хамааралтай артерын даралт ихсэлт, хуян хөөрөх, мөн улирлын шинжтэй харшлын гаралтай ханиад, тархалт дэгдэлттэй холбоотой ханиад, ажлын онцлогтой хамааралтай /автотээврийн хяналтын улсын байцаагч нар/ уушгины архаг үрэвсэл, бөглөрөл, зүрх судасны дутагдал, / оффист суугаа хөдөлмөр эрхэлж буй албан хаагч нар/ тархины хэт ачааллаас үүдсэн толгойн өвдөлт, тархины цусан хангамжийн дутагдал, ядаргаа гэсэн оноштой байна.</p>	100
12	<p>5.3.4. Байгууллагын албан хаагчдын дунд "Эрүүл агаар эм" сэдэвт идэвхитэй амралт, биеийн тамир, спортын төрөл бүрийн аварга шалгаруулах тэмцээнийг жилд 2-оос доошгүй удаа зохион байгуулах</p>	<p>Байгууллагын биеийн тамир, спорт хамтлагтай хамтран "Цасны баяр"-ын арга хэмжээ зохион байгуулах</p> <p>Байгууллагын биеийн тамир, спорт хамтлагтай хамтран "Байгууллагын аварга" шалгаруулах олон төрөлт тэмцээн зохион байгуулах</p> <p>Байгууллагын биеийн тамир, спорт хамтлагтай хамтран байгууллагын 50 жилийн ойн нэрэмжит "Салбарын аварга" шалгаруулах олон төрөлт тэмцээн зохион байгуулах</p> <p>Байгууллагын биеийн тамир, спорт хамтлагтай хамтран "Замд гаръя" явган аялалын арга хэмжээ зохион байгуулах</p>	<p>2019 оны 03 дугаар сарын 02-ны өдөр байгууллагын "Цасны баяр"-т спорт хамтлагийн гишүүн, эмчийн хувьд зохион байгуулалтын ажилд оролцож амжилттай зохион байгуулав.</p> <p>2019 оны 06 дугаар сарын 08-ны өдрөөс 2019 оны 6 дугаар сарын 16-ны хооронд Нийтийн тээврийн үйлчилгээний газар үүсэн байгуулагдсаны 50 жилийн ойг угтсан /15 байгууллага/ салбар нэгж, аж ахуйн нэгжүүдийн дунд зохиогдсон 7 төрөлт спортын арга хэмжээг зохион байгуулсан.</p>	100
			<p>Хугацаа болоогүй</p>	0

		Байгууллагын биеийн тамир, спорт хамтлагтай хамтран байгууллагын ажилтан албан хаагдыг хамруулсан явган аялал зохион байгуулах	Хугацаа болоогүй	0
			ДУНДАЖ ХУВЬ - 96.5%	

ХЯНАСАН:  
 ЗАХИРГААНЫ УДИРДЛАГА, САНХҮҮГИЙН  
 ХЭЛТСИЙН ДАРГА  М.МӨНХБАЯР

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:  
 ХҮНИЙ НӨӨЦИЙН МЭРГЭЖИЛТЭН  Л.ЭНХ-УНДРАЛ